



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/109/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа Уул Аудит ХХК

Захирал: Ч.Мөнхтуяа

Цахим хаяг: uwaaул.audit@gmail.com

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын ТАЙЛАН	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	18
4.2 Төлбөрийн акт	18
4.3 Албан шаардлага	18
4.3 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
НХМ	Нэг хэвийн маягт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/119
танай -ны № -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

19020383

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,369,673.00	42,511,972.02
35	БАРАА МАТЕРИАЛ	29,369,673.00	42,511,972.02
351	Түүхий эд материал	2,409,650.00	3,928,000.00
35110	Тусгай зориулалттай материал	2,260,000.00	3,878,000.00
35130	Эм боох материал	149,650.00	50,000.00
354	Хангамжийн материал	26,960,023.00	38,583,972.02
35410	Бичиг хэргийн материал	448,300.00	542,300.00
35420	Аж ахуйн материал	13,358,226.00	12,729,010.02
35460	Хүнсний материал	228,450.00	677,630.00
35470	Бусад хангамжийн материал	12,925,047.00	24,635,032.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,666,480,687.22	1,604,696,142.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,666,480,687.22	1,604,696,142.82
392	Биет хөрөнгө	1,623,596,687.22	1,561,812,142.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,523,791,577.00	1,525,284,036.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(60,604,559.96)	(110,693,414.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	6,450,000.00	6,450,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,805,000.00)	(6,450,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	116,703,609.20	127,524,346.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(73,246,531.07)	(86,186,912.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,116,105.30	50,130,105.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,511,890.14)	(35,530,014.67)
39214	Бусад үндсэн хөрөнгө	118,833,900.00	118,833,900.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(26,789,894.76)	(33,373,789.74)
39217	Ном	3,659,371.65	5,823,886.73
393	Биет бус хөрөнгө	42,884,000.00	42,884,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	42,884,000.00	42,884,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,695,850,360.22	1,647,208,114.84
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,695,850,360.22	1,647,208,114.84
51	Засгийн газрын хувь оролцоо	1,695,850,360.22	1,647,208,114.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	242,035,023.90	242,035,023.90
51101	Өмч: (төрийн	242,035,023.90	242,035,023.90
512	Хуримтлагдсан үр дүн	853,286,846.57	804,644,601.19
51210	Өмнөх үеийн үр дүн	853,286,846.57	853,286,846.57
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(48,642,245.38)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	600,528,489.75	600,528,489.75
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,695,850,360.22	1,647,208,114.84

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,732,309,282.81	779,180,348.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	973,536,682.81	19,844,821.08
120	Нийтлэг татварын бус орлого	973,536,682.81	19,844,821.08
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	963,809,620.90	12,473,711.08
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	9,727,061.91	7,371,110.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	758,772,600.00	759,335,527.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	596,972,300.00	570,144,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	596,972,300.00	570,144,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,286,500.00	36,695,727.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,286,500.00	36,695,727.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	136,513,800.00	152,494,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	136,513,800.00	152,494,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	818,739,599.42	827,822,593.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	818,739,599.42	827,822,593.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	723,069,410.48	764,029,273.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	452,656,844.10	462,604,076.34
210101	Үндсэн цалин	298,165,665.10	285,716,980.16
210102	Нэмэгдэл	113,675,489.00	171,648,207.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,012,000.00	0.00
210104	Урамшуулал	28,803,690.00	5,238,889.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,658,421.96	60,388,930.34
210201	Тэтгэврийн даатгал	40,479,972.30	42,349,068.69
210202	Тэтгэмжийн даатгал	3,869,372.04	4,666,704.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,835,814.45	3,706,483.01
210204	Ажилгүйдлийн даатгал	861,305.73	878,789.77
210205	Эрүүл мэндийн даатгал	8,611,957.44	8,787,884.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135,513,800.00	148,354,573.00
210301	Гэрэл, цахилгаан	2,515,139.00	4,466,414.00
210302	Түлш, халаалт	132,798,661.00	143,688,159.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,597,365.00	4,577,467.98
210401	Бичиг хэрэг	572,700.00	626,127.00
210402	Тээвэр, шатахуун	580,000.00	554,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	525,000.00
210404	Ном, хэвлэл	131,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	323,650.00	1,037,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,190,015.00	1,833,990.98
2105	Нормативт зардал	9,967,135.00	7,270,970.00

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	128,000.00	199,650.00
210502	Хоол, хүнс	8,809,135.00	6,911,320.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,030,000.00	160,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	140,000.00	140,000.00
210702	Дотоод албан томилолт	140,000.00	140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,353,850.00	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,353,850.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,181,994.42	79,693,255.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,000.00	1,973,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,265,061.91	444,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,876,932.51	77,276,255.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	95,670,188.94	63,793,320.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,153,300.00	41,658,470.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,946,800.00	9,086,470.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	27,399,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,286,500.00	4,850,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	920,000.00	322,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	3,140,327.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	3,140,327.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	62,516,888.94	18,994,523.32
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,516,888.94	18,994,523.32
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	913,569,683.39	(48,642,245.38)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,137,584.09	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	2,137,584.09	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	911,432,099.30	(48,642,245.38)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	242,035,023.90	601,340,475.57	-58,957,238.55	784,418,260.92
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	811,985.82	811,985.82
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	242,035,023.90	601,340,475.57	-58,145,252.73	785,230,246.74
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	(811,985.82)	0.00	(811,985.82)
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	911,432,099.30	911,432,099.30
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	242,035,023.90	600,528,489.75	853,286,846.57	1,695,850,360.22
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	242,035,023.90	600,528,489.75	853,286,846.57	1,695,850,360.22
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн			(48,642,245.38)	(48,642,245.38)
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	242,035,023.90	600,528,489.75	804,644,601.19	1,647,208,114.84

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	758,772,600.00	759,335,527.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	758,772,600.00	759,335,527.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	596,972,300.00	570,144,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	596,972,300.00	570,144,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,286,500.00	36,695,727.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,286,500.00	36,695,727.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	136,513,800.00	152,494,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	136,513,800.00	152,494,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	758,682,600.00	756,317,527.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	758,682,600.00	756,317,527.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	660,071,166.06	691,977,276.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	452,656,844.10	462,604,074.45
210101	Үндсэн цалин	298,165,665.10	255,713,476.10
210102	Нэмэгдэл	113,675,489.00	201,651,709.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,012,000.00	0.00
210104	Урамшуулал	28,803,690.00	5,238,889.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,658,421.96	60,388,932.23
210201	Тэтгэврийн даатгал	40,479,972.30	42,357,473.36
210202	Тэтгэмжийн даатгал	3,869,372.04	4,658,303.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,835,814.45	3,706,482.83
210204	Ажилгүйдлийн даатгал	861,305.73	878,788.47
210205	Эрүүл мэндийн даатгал	8,611,957.44	8,787,883.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135,513,800.00	148,354,573.00
210301	Гэрэл, цахилгаан	2,515,139.00	4,466,414.00
210302	Түлш, халаалт	132,798,661.00	143,688,159.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,582,950.00	3,286,127.00
210401	Бичиг хэрэг	328,500.00	495,727.00
210402	Тээвэр, шатахуун	580,000.00	499,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	749,400.00
210404	Ном, хэвлэл	244,350.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	165,000.00	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,465,100.00	1,381,500.00
2105	Нормативт зардал	4,855,650.00	10,609,570.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	277,650.00	500,000.00
210502	Хоол, хүнс	3,548,000.00	7,409,570.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,030,000.00	2,700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	140,000.00	140,000.00
210702	Дотоод албан томилолт	140,000.00	140,000.00

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,332,500.00	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,332,500.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,331,000.00	5,594,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,900.00	1,377,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,268,100.00	4,217,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,611,433.94	64,340,250.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,094,545.00	42,205,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,888,045.00	9,037,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	27,399,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,286,500.00	4,850,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	920,000.00	918,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	3,140,327.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	3,140,327.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	62,516,888.94	18,994,523.32
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,516,888.94	18,994,523.32
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	90,000.00	3,018,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	90,000.00	3,018,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	90,000.00	3,018,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	90,000.00	3,018,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	90,000.00	3,018,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(90,000.00)	(3,018,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	722,639,800.00	700,504,949.68	22,134,850.32	96.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	722,639,800.00	700,504,949.68	22,134,850.32	96.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	709,990,900.00	690,549,549.68	19,441,350.32	97.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	473,059,700.00	462,604,074.45	10,455,625.55	97.8
210101	Үндсэн цалин	317,230,900.00	255,713,476.10	61,517,423.90	80.6
210102	Нэмэгдэл	109,476,100.00	201,651,709.35	-92,175,609.35	184.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,444,000.00	0	15,444,000.00	-
210104	Урамшуулал	30,908,700.00	5,238,889.00	25,669,811.00	16.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,863,000.00	60,388,932.23	3,474,067.77	94.6
210201	Тэтгэврийн даатгал	44,940,600.00	42,357,473.36	2,583,126.64	94.3
210202	Тэтгэмжийн даатгал	4,730,600.00	4,658,303.77	72,296.23	98.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,784,500.00	3,706,482.83	78,017.17	97.9
210204	Ажилгүйдлийн даатгал	946,100.00	878,788.47	67,311.53	92.9
210205	Эрүүл мэндийн даатгал	9,461,200.00	8,787,883.80	673,316.20	92.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	151,494,900.00	148,354,573.00	3,140,327.00	97.9
210301	Гэрэл, цахилгаан	7,603,500.00	4,466,414.00	3,137,086.00	58.7
210302	Түлш, халаалт	143,691,400.00	143,688,159.00	3,241.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	200,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	4,095,000.00	4,073,400.00	21,600.00	99.5
210401	Бичиг хэрэг	350,000.00	350,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	499,500.00	500.00	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	750,000.00	749,400.00	600.00	99.9
210404	Ном, хэвлэл	335,000.00	933,000.00	(598,000.00)	278.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.00	160,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,381,500.00	618,500.00	69.1
2105	Нормативт зардал	12,853,300.00	10,609,570.00	2,243,730.00	82.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.00	500,000.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	9,653,300.00	7,409,570.00	2,243,730.00	76.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,700,000.00	2,700,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	223,000.00	140,000.00	83,000.00	62.8
210702	Дотоод албан томилолт	223,000.00	140,000.00	83,000.00	62.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,402,000.00	3,379,000.00	23,000.00	99.3

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,400,000.00	1,377,000.00	23,000.00	98.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,002,000.00	2,002,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,648,900.00	9,955,400.00	2,693,500.00	78.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,648,900.00	9,955,400.00	2,693,500.00	78.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,728,400.00	9,037,400.00	2,691,000.00	77.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	920,500.00	918,000.00	2,500.00	99.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	722,639,800.00	700,504,949.68	22,134,850.32	78.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	570,144,900.00	551,150,376.68	18,994,523.32	100.0
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	570,144,900.00	551,150,376.68	18,994,523.32	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	152,494,900.00	149,354,573.00	3,140,327.00	-
320001	Орон нутгийн төсвөөс	152,494,900.00	149,354,573.00	3,140,327.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0	0.00	
610001	Төсвийн байгууллага	1	1		100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	39	39		100.0
620001	Удирдах ажилтан	1	1		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	22	22		100.0
620003	Үйлчлэх ажилтан	16	16		100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	462	462		100.0
630001	Төрийн өмчит ЕБС	462	462		100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		36,695,727.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		36,695,727.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,445,727.00
2104	Хангамж, бараа материалын зардал		145,727.00
210401	Бичиг хэрэг		145,727.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		4,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		4,300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		32,250,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		32,250,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		27,399,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		4,850,600.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		36,695,727.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		36,695,727.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		36,695,727.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн ашиглах жилийг сунгах, авлага, өглөгийн тооцоо нийлэх, хөрөнгийн дансны ангилалтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-аас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Уваа уул Аудит ХХК-ийн аудитор Б.Буяндэлгэр, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанар хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Уваа уул аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургууль нь бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг. Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа БШУС-ын 2021 оны бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/26 дугаар тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд Төв аймгийн Санхүү хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар Төв аймгийн Санхүү хяналт, аудитын албаны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 816,509.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,165.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,715.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь улсын төсвөөс 570,144.9 мянга, орон нутгийн төсвөөс 152,494.9 мянган төгрөгийн санхүүжилт, нийт 722,639.8 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 36,695.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар 36,695.7 мянган төгрөг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 10,820.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,634.1 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,014.0 мянган төгрөгийн бусад хөрөнгө, нийт 15,491.7 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 3,018.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 12,473.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 7,371.1 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 28,000.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 22,228.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 42,512.0 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1,604,696.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	29,369.7	42,512.0	13,142.3
Үндсэн хөрөнгө	1,666,480.7	1,604,696.1	(61,784.6)
Нийт хөрөнгө	1,695,850.4	1,647,208.1	(48,642.3)
ЗГ-н оруулсан капитал	242,035.0	242,035.0	-
Хуримтлагдсан үр дүн	853,286.9	804,644.6	(48,642.3)
Нийт ер төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,695,850.4	1,647,208.1	(48,642.3)

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын данс өмнөх оноос 13,142.3 мянган төгрөгөөр өссөн нь 7,371.1 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан хангамжийн материалын өсөлтөөс голлон шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө данс тайлант оны элэгдлийн зардлаас голлон шалтгаалж 61,784.6 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 657,421.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 155,000.0 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 812,421.4 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 65,218.4 мянган төгрөгөөр бууруулан 722,639.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 152,494.9 мянга, улсын төсвөөс 570,144.9 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 570,144.9 мянга, орон нутгийн төсвөөс 152,494.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 700,505.0 мянган төгрөгийг зарцуулж, 22,134.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 700,505.0 мянган төгрөг буюу 96.9 хувьтай байгаа нь цалин хөлсний зардлыг 13,929.7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3,410.7 мянга, хоол хүнсний зардлыг 2,243.7 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал/үдийн цай/-ыг 2,691.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас голлон шалтгаалсан байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 10,820.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,634.1 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,014.0 мянган төгрөгийн бусад хөрөнгө, нийт 15,491.7 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 3,018.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 12,473.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийг бүлэг дотор зардлын хэтрэлт үүсгэж нэмэгдэл цалин хөлсийг 84.2 хувиар буюу 92,175.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 922,393.8 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 149 мэдээллийг хугацаандаа бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 74,857.9 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулах алдаа зөрчил илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага гараагүй болно.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 74,857.9 мянган төгрөгийн хөрөнгө байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-н тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн тооллогын баримтад эд хариуцагчийг карт, тооцоо бодсон баримт, тооллогын комиссын илтгэх хуудас, өмч хамгаалах зөвлөлийн тэмдэглэл, байгууллагын удирдлагад танилцуулсан тэмдэглэл, тооллогын баталгаа хийгдээгүй зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй...”, 72 дугаар зүйлийн 72.4-д “Тооллогын комисс дараах үүрэгтэй...” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тооллогыг ажлыг чанартай явуулж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган
төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төв аймгийн Баян сумын Ерөнхий боловсролын сургууль	2	74,857.9					-	-	2	74,857.9
	ДҮН	2	74,857.9					-	-	2	74,857.9

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn